



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2012 оны 07 сарын 30 өдөр

Дугаар 4/447

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын 2012 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам”, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” 359 дүгээр тушаалын Бямбаа овогтой Цогтбаатартай холбогдох хэсгийн “АНУ-ын Колорадогийн их сургуулийн магистрантурт 2 жил” гэснийг “Канад Улсын Симон Фрэйсерийн их сургуулийн докторантурт 3 жил” гэж, 2008 оны 9 дүгээр сарын 17-ны өдрийн “Гадаадад зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 476 дугаар тушаалын Халтмаа овогтой Энэбиштэй холбогдох хэсгийн “Колорадогийн их сургуулийн магистрантурт эрх зүйн чиглэлээр” гэснийг “Виржинийн олон улсын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлага, менежментийн чиглэлээр” гэж, 2010 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 568 дугаар тушаалын Хишигсүх овогтой Отгонхүүтэй холбогдох хэсгийн “АНУ-ын Баруун Виржиния их сургуулийн магистрантурт уул уурхайн боловсруулалт, эдийн засгийн чиглэлээр” гэснийг “Австрали Улсын Кюртины их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр” гэж, 2011 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 276 дугаар тушаалын хавсралтын Пүрэвжав овогтой Авралт-Одтой холбогдох хэсгийн Жорж Вашингтоны их сургуулийн докторантурт төсвийн шинжилгээ, хөгжлийн эдийн засийн чиглэлээр 3 жил” гэснийг “Аризонагийн их сургуулийн магистрантурт хөгжлийн эдийн засаг, стратеги төлөвлөлтийн чиглэлээр 2 жил” гэж,

мөн тушаалын хавсралтын Аюуш овогтой Ариунболдтой холбогдох хэсгийн “АНУ-ын Калифорнийн олон улсын их сургуулийн магистрантурт эрүүгийн эрх зүйн чиглэлээр” гэснийг “Австрали Улсын Централ Квийнслэнд их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр” гэж, 2012 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” 14 дүгээр тушаалын Буянтөр овогтой Оюунтунгалагтай холбогдох хэсгийн “Кореа их сургуулийн докторантурт 2 жил” гэснийг “Гүгмин их сургуулийн докторантурт 3 жил” гэж, мөн тушаалын Төмөр-Уяа овогтой Жамбалцэрэнтэй холбогдох хэсгийн “АНУ-ын Жорж Вашингтоны их сургуулийн” гэснийг “Австрали Улсын Нью Кастле их сургуулийн” гэж, мөн тушаалын Энхтөвшин овогтой Далантайтай холбогдох хэсгийн “Мэдээлэл, шуудан, харилцаа холбооны газрын захиалгаар Юан Зэ их сургуулийн” гэснийг “Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн захиалгаар Тайваний Шинжлэх ухаан, технологийн үндэсний их сургуулийн” гэж, мөн тушаалын Пүрвээ овогтой Анартай холбогдох хэсгийн “докторантурт 3 жилийн” гэснийг “магистрантурт 2 жилийн” гэж, мөн тушаалын Намсрай овогтой Зоригтсайхантай холбогдох хэсгийн “1 жилийн” гэснийг “1,5 жилийн” гэж, 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” А/348 дугаар тушаалын хавсралтын Гантөмөр овогтой Ононтой холбогдох хэсгийн “магистрантур 2 жил” гэснийг “докторантурт 3 жил” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн “Сургалтын төрийн сангийн зээлээр гадаадад суралцуулах тухай” А/348 дугаар тушаалын хавсралтын Бямбаа овогтой Цогтбаатартай холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.



Ё.ОТГОНБАЯР